



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ДАРХАНЫ ДУЛААНЫ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН 2022 ОНЫ СА
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2023/15/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэ
дараах хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал.....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
4.5.1 Завсрын аудитын талаар.....	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.1 Төлбөрийн акт	15
5.2 Албан шаардлага	15
5.3 Зөвлөмж.....	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНМАУ	Бүгд найрамдах монгол ард улс
ДХТ	Дулаан хуваарилах төв
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТЗБАХ	Техник, зохион байгуулалтын арга хэмжээ
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**“ДАРХАНЫ ДУЛААНЫ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.БАТЖАРГАЛ
ТАНАА**

2023.03.15 № 157
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дарханы дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Дарханы дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан “Төрөл бүрийн ган хаалт” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалт нь 2 удаа хүчингүй болсонтой холбоотойгоор ТБОНӨХБАҮХАТ хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.1-д заасны дагуу ОХУ-ын “Сибарма Пласт-Импекс” ХХК-тай шууд гэрээ байгуулжээ.

Аудитын гол асуудал

Тайлант хугацаанд компанийн гүйцэтгэх захирал Д.Батжаргалыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 5 дугаар тогтоолоор томилсон бөгөөд шинээр томилогдсон гүйцэтгэх захирал Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компанийн жилийн төлөвлөгөөнд 20 зорилтын хүрээнд 154 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

009020244

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)


Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		1-р сарын 01	12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	107,143,756.73	344,453,526.05
1.1.2	Дансны авлага	1,630,620,541.99	530,843,989.10
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	2,623,157.39	16,197,628.34
1.1.4	Бусад авлага	33,151,604.08	15,649,227.09
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	569,765,466.66	520,852,344.64
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	380,373,293.73	30,448,393.74
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,723,677,820.58	1,458,445,108.96
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	24,781,474,405.72	24,717,714,286.05
1.2.2	Биет бус хөрөнгө	909,616,358.65	895,598,551.90
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	25,691,090,764.37	25,613,312,837.95
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	28,414,768,584.95	27,071,757,946.91
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	698,373,819.71	191,797,313.50
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	75,163,579.63	-
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	342,940,000.00
2.1.1.6	Хүүний өглөг	-	-
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	449,660,632.36	132,248,361.15
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,223,198,031.70	666,985,674.65
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,223,198,031.70	666,985,674.65
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	17,920,722,852.44	17,920,722,852.44
2.3.2	Өмч: - хувийн	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,915,919,985.26	2,915,919,985.26
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	2,552,373,295.20	2,802,982,550.80
2.3.9	Хуримтлагдсан ашиг	3,802,554,420.35	2,765,146,883.76
2.3.11	Эздийн өмчийн дүн	27,191,570,553.25	26,404,772,272.26
2.4	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	28,414,768,584.95	27,071,757,946.91



2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
01	Борлуулалтын орлого (цэвэр)	10,926,949,756.37	11,049,218,514.30
02	Борлуулалтын өртөг	6,384,731,731.16	7,148,836,076.72
03	Нийт ашиг (алдагдал)	4,542,218,025.21	3,900,382,437.58
04	Түрээсийн орлого	486,000.00	1,620,000.00
05	Хүүний орлого	-	-
06	Ногдол ашгийн орлого	-	-
07	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
08	Бусад орлого	410,878,826.63	588,137,789.73
09	Борлуулалт, маркетингийн зардал	1,593,389,701.93	1,929,493,392.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	3,096,835,029.14	3,241,607,012.27
11	Санхүүгийн зардал	10,402,490.68	20,182,755.11
12	Бусад зардал	211,467,505.32	247,094,196.55
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	153,068,441.76	91,146,131.57
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(111,580,316.99)	(1,039,383,260.19)
19	Орлогын татварын зардал	4,148,512.48	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(115,728,829.47)	(1,039,383,260.19)
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(115,728,829.47)	(1,039,383,260.19)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		



2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	17,920,722,852.44	-	2,915,919,985.27	2,552,373,295.20	3,802,554,420.35	27,191,570,553.26
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	17,920,722,852.44	-	2,915,919,985.27	2,552,373,295.20	3,802,554,420.35	27,191,570,553.26
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өөрчлөлт	-	-	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	-
Ногдол ашиг	-	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн	-	-	-	-	-	-
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,920,722,852.44	-	2,915,919,985.27	2,552,373,295.20	3,802,554,420.35	27,191,570,553.26
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өөрчлөлт	-	-	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	250,609,255.60	1,975,723.60	252,584,979.20
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	(1,039,383,260.20)	(1,039,383,260.20)
Ногдол ашиг	-	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн	-	-	-	-	-	-
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,920,722,852.44	-	2,915,919,985.27	2,802,982,550.80	2,765,146,883.75	28,404,772,272.26



2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан


(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 он	2022 он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	11,651,128,548.70	12,303,661,030.51
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	11,053,139,257.67	11,682,462,705.34
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
	Буцаан авсан албан татвар	477,272.73	-
	Бусад мөнгөн орлого	597,512,018.30	621,198,325.17
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	11,335,243,325.55	11,719,277,206.19
	Ажиллагчдад төлсөн	2,767,661,975.96	3,179,629,001.37
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,035,655,253.00	1,087,500,000.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	4,511,127,038.99	4,527,640,621.81
	Ашиглалтын зардалд төлсөн	291,866,823.71	384,233,213.95
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	112,446,322.92	143,912,102.54
	Хүүний төлбөрт төлсөн	10,402,490.68	20,182,755.11
	Татварын байгууллагад төлсөн	1,284,794,998.82	961,448,714.44
	Даатгалын төлбөрт төлсөн	10,686,712.00	10,955,887.00
	Бусад мөнгөн зарлага	1,310,601,709.47	1,403,774,909.97
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	315,885,223.15	584,383,824.32
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	690,014,055.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	690,014,055.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(690,014,055.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	451,199,072.69	1,139,471,164.21
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	451,199,072.69	1,139,471,164.21
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
	Төрөл бүрийн хандив	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	696,199,072.69	796,531,164.21
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	696,199,072.69	796,531,164.21
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
	Төлсөн ногдол ашиг	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(245,000,000.00)	342,940,000.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	70,885,223.15	237,309,769.32
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	36,258,533.58	107,143,756.73
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	107,143,756.73	344,453,526.05



2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт		Хэмжих нэгж	2021 оны гүйцэтгэл	2022 оны			
					Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Худалдаж авсан дулаан		мян.Гкал	572.1	584.80	601.30	16.5	2.8
	Үүнээс:	Ураар	мян.Гкал	12.20	14.34	2.1	17.5	184.4
		Усаар	мян.Гкал	572.60	586.96	14.4	2.5	0.3
	Худалдаж авсан ДЭХ-ний өртөг		сая.төг	4,122.2	4,199.90	4,431.65	231.7	5.5
	ДЭХ-ний алдагдал	хувиар	хувь	15.35%	15.35%	-	-	(2.5)
		биетээр	мян.Гкал	87.89	90.12	2.2	2.5	(2.2)
Борлуулах дулааны эрчим хүч		мян.Гкал	486.7	496.91	511.18	14.3	2.9	
2	Нийт орлого		мян.төг	11,338,314.7	11,117,574.1	11,638,976.3	521,402.2	4.7
	Үүнээс:	Борлуулалтын орлого	мян.төг	10,887,574.13	11,049,218.51	161,644.4	1.5	8.0
		Үйл ажиллагааны бус орлого	мян.төг	230,000.00	589,757.79	359,757.8	156.4	174.2
Борлуулалтын орлого цуглуулалт		мян.төг	11,448,954.3	10,887,574.13	12,180,690.62	1,293,116.5	11.9	
3	Нийт зардал		мян.төг	11,449,894.9	12,404,625.40	12,678,359.56	273,734.2	2.2
	Үүнээс:	Үйл ажиллагааны зардал	мян.төг	8,128,850.80	7,945,967.39	(182,883.4)	(2.2)	0.1
		Худалдаж авсан ДЭХ-ний өртөг	мян.төг	4,199,900.00	4,431,649.01	231,749.0	5.5	9.8
		Үйл ажиллагааны бус зардал	мян.төг	75,874.60	300,743.16	224,868.6	296.4	163.1
ҮХЭ-ийн зардал		мян.төг	1,736,055.9	1,901,936.36	1,764,745.68	(137,190.7)	(7.2)	
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/		мян.төг	(111,580.2)	(1,287,051.26)	(1,039,383.25)	247,668.0	(19.2)
5	Татварын дараах ашиг /алдагдал/		мян.төг	(115,733.2)	(1,287,051.26)	(1,039,383.25)	247,668.0	(19.2)
6	Борлуулалтын орлогын 1 төг-т ногдох зардал		мян.төг	1,009.8	1.116	1.089	(0.0)	(2.4)
7	Нийт авлага		мян.төг	1,666,395.3	878,848.94	562,740.90	(316,108.0)	(36.0)
	Үүнээс:	Борлуулалтын авлага	мян.төг	783,277.04	555,271.81	(228,005.2)	(29.1)	(61.3)
		ЗГ-аас авах борлуулалтын авлага	мян.төг	-	-	-	-	-
		Бусад	мян.төг	95,571.90	7,469.09	(88,102.8)	(92.2)	(128.9)
8	Нийт өглөг		мян.төг	1,223,198.0	1,106,900.00	667,035.73	(439,864.3)	(39.7)
	Үүнээс:	УХӨТ	мян.төг	-	-	-	-	-
БХӨТ		мян.төг	1,106,900.00	667,035.73	(439,864.3)	(39.7)	(9.0)	
9	Нийт ажиллагсад		тоо	184.0	192.00	184.00	(8.0)	(4.2)
10	Цалингийн сан		мян.төг	3,187,419.3	3,912,440.75	3,749,690.64	(162,750.1)	(4.2)
11	Нэг сарын дундаж цалин	Нийт ажиллагсдын	Төгрөг	1,698,108.0	1,698,229.5	121.5	0.0	1.6
		Удирдлагын	Төгрөг	4,518,084.4	4,468,445.3	(49,639.1)	(1.1)	4.2
		ИТА-ын	Төгрөг	1,762,022.1	1,772,098.3	10,076.3	0.6	0.2
		Ажилчдын	Төгрөг	1,278,516.2	1,274,997.5	(3,518.8)	(0.3)	1.1
12	Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт		мян.төг	962,219.0	1,281,364.6	1,196,230.0	(85,134.6)	(6.6)
	Үүнээс:	Их засвар	мян.төг	950,110.0	876,010.0	(74,100.0)	(7.8)	(9.9)
		ТЗБАХ	мян.төг	190,374.6	181,740.0	(8,634.6)	(4.5)	0.0
		Хөрөнгө оруулалт	мян.төг	140,880.0	138,480.0	(2,400.0)	(1.7)	(13.9)



 ХТ054305922599

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компанийн үйл ажиллагаа

“Дарханы дулааны сүлжээ” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2018 оны А/195 дугаар тушаалаар компанийн эрхэм зорилго, 2030 он хүртэлх алсын хараа, үнэт зүйлс, уриа чанарын бодлогыг дараах байдлаар тодорхойлж баталжээ. Үүнд:

- **Эрхэм зорилго:** Дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлэн урагшилж, дулааны эрчим хүчийг хамгийн бага алдагдалтайгаар түгээж, хэрэглэгчээ дээдэлсэн чанартай үйлчилгээ үзүүлнэ.
- **Алсын хараа:** 2030 он гэхэд хүний хөгжлийг дээдэлсэн, байгаль орчинд ээлтэй, ухаалаг технологи нэвтрүүлсэн, салбартаа тэргүүлэгч компани болно.
- **Үнэт зүйлс:** Чадварлаг бүтээлч ажилтан, эерэг хандлага, эрүүл аюулгүй орчин, багийн ажиллагаа, түүхэн замнал
- **Уриа:** Бидний сэтгэл зүтгэл, таны дулаан орчин гэж тодорхойлсон байна.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах, тусгай зөвшөөрлийн хүрээнд Дархан-Уул аймгийн төвийн аж ахуйн нэгж, байгууллага, орон сууцны байрыг дулааны эрчим хүчээр найдвартай хангах гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн өмчит хувьцаат компани статустай ба компанийн дүрэмд өмчийн 70 хувийг Эрчим хүчний яам, 30 хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тус тус эзэмшиж байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Төлөөлөн удирдах зөвлөл 2022 онд компанийн удирдлагыг ТБОНӨТХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.6, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 2.10 дахь заалтуудын дагуу томилсон нь холбогдох хууль эрх зүйн актуудтай нийцэж байна.

Тус компани нь Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдан хэрэгжсэн, Хөдөлмөрийн тухай хууль шинэчлэгдсэн, мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсон байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

Гүйцэтгэх захирлын 2021 оны А/05 дугаар тушаалаар баталсан зохион байгуулалтаар дотоод хяналт, мониторингийн хэлтэст 6 орон тоо баталжээ. Тус хэлтэс 2022 онд нийт 17 ажил төлөвлөснөөс санхүүгийн чиглэлээр 9 ажлын төлөвлөгөө боловсруулж гүйцэтгэх захирлаар батлуулан хэрэгжилтийг ТУЗ-д тайлагнадаг байна. Илэрсэн зөрчлийг тухай бүр арилгуулж, хэрэгжилтийг тооцсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн болно.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Дархан дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

“Дархан дулааны сүлжээ” ТӨХК 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,343,010.7 мянган төгрөгөөр буюу 4.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	107,143.8	344,453.5	237,309.7
Богино хугацаат хөрөнгө оруулалт	-	-	-
Авлага	1,666,395.2	562,690.8	(1,103,704.4)
Урьдчилгаа	380,373.3	30,448.4	(349,924.9)
Бараа материал	569,765.5	520,852.3	(48,913.2)
Үндсэн хөрөнгө	24,781,474.4	24,717,714.3	(63,760.1)
Биет бус хөрөнгө	909,616.4	895,598.6	(14,017.8)
Нийт хөрөнгийн дүн	28,414,768.6	27,071,757.9	(1,343,010.7)
Өр төлбөрийн дүн	1,223,198.0	666,985.7	(556,212.3)
Богино хугацаат өглөг	1,223,198.0	666,985.7	(556,212.3)
Урт хугацаат өглөг	-	-	-
Эздийн өмч	27,191,570.6	26,404,772.3	(786,798.3)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө, өмчийн дүн	28,414,768.6	27,071,757.9	(1,343,010.7)

Касс дахь бэлэн мөнгө дансанд үндсэн үйл ажиллагааны орлогоос 741,629.5 мянган төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлогоос 118,064.4 мянган төгрөг, банк дахь харилцах данснаас 100,000.0 мянган төгрөг төвлөрснөөс оны эцэст 43,867.0 мянган төгрөгийн үлдэгдэл байна.

Банк дахь харилцах дансанд үндсэн үйл ажиллагааны орлогоос 10,966,143.1 мянга, үндсэн бус үйл ажиллагааны орлогоос 415,904.3 мянган төгрөг төвлөрч, үлдэгдэл 300,586.5 мянган төгрөг байна.

Авлага дансны үлдэгдэлд аж ахуйн нэгж байгууллагаас авах дулааны төлбөр 546,493.2 мянга, НДШ-ийн 16,197.6 мянган төгрөгийн авлагын үлдэгдэл тус тус эзэлж байна.

Тайлант онд авлагын үлдэгдэл 1,103,704.4 мянган төгрөгөөр буурахад Засгийн газраас авах хөнгөлөлтийн авлага 1,342,807.0 мянган төгрөг төлөгдсөнөөс шалтгаалжээ.

Найдваргүй авлагын хасагдуулгыг НББ-ийн бодлогын баримт бичигт авлагын насжилтаас хамааран 1.5-40 хүртэл хувиар тооцохоор заасан бөгөөд тайлант онд 17,542.1 мянган төгрөг нэмж бүртгэснээр 65,730.8 мянган төгрөгийн найдваргүй авлага бүртгэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 520,852.3 мянган төгрөг болж өнгөрсөн оноос 48,913.2 мянган төгрөгөөр буурахад дулааны сэлбэг хэрэгсэл 41,276.0 мянга, аюулгүйн нөөцийн материал 5,845.1 мянган төгрөгийг тус тус зарцуулсан нь нөлөөлжээ.

Тайлант онд худалдан авалтаар 1,136,655.5 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, 1,185,568.7 мянган төгрөгийн материалыг компанийн үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл буурахад ТӨБЗГ-ын 2022 оны 09 дүгээр сарын 431 дүгээр тогтоолоор 184,481.6 дулааны шугам, узелийг акталж, 411 дүгээр тогтоолоор 250,609.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн данс бүртгэлд тусгаж, 682,014.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 1,764,745.7 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан нь нөлөөлжээ.

Биет бус хөрөнгө 14,017.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд байгуулсан элэгдлийн зардалтай холбоотой байна.

Богино хугацаат өглөгийн дансны үлдэгдэлд худалдан авсан дулааны эрчим хүчний 156,328.1 мянга, бусад байгууллагад төлөх 35,469.2 мянга, банкны богино хугацаат зээл 342,940.0 мянга, 132,248.3 мянган төгрөгийн урьдчилж орсон орлого байна.

Компанийн богино хугацаат өр төлбөр 556,212.3 мянган төгрөгөөр буурахад дулааны эрчим хүчний өр 154,596.0 мянга, татварын өр 75,163.6 мянга, гэрээний дагуу худалдан авсан үндсэн хөрөнгөд төлөх 355,522.9 мянга, урьдчилж олсон орлого 317,412.3 мянган төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлжээ.

Шалгагдагч байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт аж ахуйн нэгж, хувь хүнээс хандивласан буюу бэлэглэсэн үндсэн хөрөнгийг эзэмшигчийн өмчийн бусад хэсэгт бүртгэнэ гэж заасны дагуу үнэ төлбөргүй баланст шилжиж ирсэн 250,609.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг өмчийн өөрчлөлтийн тайлангийн эздийн өмчийн бусад хэсэгт бүртгэсэн, өмнөх оны зардлыг залруулж 1,975.7 мянган төгрөгөөр хуримтлагдсан ашгийн дансыг нэмэгдүүлсэн, 1,039,383.3 мянган төгрөгийн тайлант үеийн алдагдал зэргээс шалтгаалж эздийн өмч буурсан байна.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт худалдан авсан ДЭХ, дулаан, уур, ус түгээхтэй холбоотой ажилтнуудын цалин хөлс, материал, урсгал засвар, бусад нэмэгдэл зардлуудыг хамруулсан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Дарханы дулааны сүлжээ” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, Эрчим хүчний сайдаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2022 оны А/138 дугаар тушаалаар “Дарханы дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 11,117,574.1 мянга, нийт зардлыг

12,404,625.4 мянга, 1,287,051.3 мянган төгрөгийн алдагдалтай байхаар баталсан байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээг 1,281,364.6 мянган төгрөгөөр баталсан.

Гүйцэтгэлээр 11,638,976.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 12,678,359.6 мянган төгрөгийн зардал гарган 1,039,383.3 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 12,678,359.6 мянган төгрөг болж төлөвлөснөөс 521,402.2 мянган төгрөг буюу 4.7 хувиар давсан нь борлуулалтын орлого 161,644.4 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны бус орлого 359,757.8 мянган төгрөгөөр давж биелсэнтэй холбоотой.

Борлуулалтын орлого давж биелэхэд “Фалькон пийр” ХХК, “Өгөөж гурил” ХХК, “Эл жи эл туннель” ХХК, “Баян бридж” ХХК-ийн орон сууцуудын тоолуураар ахуйн тарифаар тооцож байсныг Эрчим хүчний зохицуулах хорооны 2022 оны 192 дугаар тогтоолын дагуу задгай талбайн хэмжээгээр буюу м2-аар тооцохоор гэрээг байгуулсан, аж ахуйн нэгж байгууллагын халаалтын задгай хэрэглээ болон халуун усны хэрэглээ нэмэгдсэн зэргээс шалтгаалсан бол үндсэн бус үйл ажиллагааны орлого давсан нь гэрээгээр шугам хоолойн угсралт, засварын ажил хийж, орлого олсонтой холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 12,678,359.6 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 273,734.2 мянган төгрөг буюу 2.2 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь уураар худалдаж авсан ДЭХ-ний биет хэмжээ төлөвлөгөөнөөс 2.14 мян.Гкал-аар, усаар худалдаж авсан ДЭХ 14.36 мян.Гкал-аар тус нэмэгдсэн, өмнөх тарифыг нэмэгдүүлж Эрчим хүчний зохицуулах хорооны 2022 оны 673 дугаар тогтоолоор 1 төг.Гкал усны тарифыг 7.9 мянган төгрөгөөр шинэчилж баталснаас худалдан авсан ДЭХ-ний өртөг 231,749.0 мянган төгрөгөөр өссөн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 48 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 1,281,364.6 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,196,230.0 мянган төгрөг зарцуулсан нь 1 ажил хэрэгжилтийн шатандаа байгаагаас шалтгаалжээ.

Тайлант онд төлөвлөгөөгөөр 1,287,051.3 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,039,383.3 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь борлуулалтын орлого төлөвлөгөөнөөс давсантай холбоотой.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 49 дүгээр тогтоолын дагуу тайлант онд 1,620.0 мянган төгрөгийн түрээсийн төлбөрийн 40 хувь болох 648.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Дархан дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулах нягтлан бодох бүртгэл, үндсэн хөрөнгөтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2023 оны 02 дугаар сарын 15-аас 2023 оны 3 дугаар сарын 15-ны хооронд Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ч.Гантулга, О.Мягмарсүрэн нар гүйцэтгэж, ахлах аудитор С.Батцэцэг, хяналтыг аудитын менежер У.Батсүрэн, дарга, тэргүүлэх, аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

“Дарханы дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 1/156 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг компанийн 2021 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн 28,414,768.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 284,147.7 төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Эрчим хүчний сайдын 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн а/1641 тоот “Удирдамж өгөх тухай”, ТӨБЗГ-ын 2022 оны 05 дугаар сарын 18-ний өдрийн А-1/947 тоот “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгүүдээр чиглэл, зааврыг хүргүүлсэн байна.

Энэ хуулийн хүрээнд гүйцэтгэх захирлын 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн Б/87 тоот тушаалаар санхүү эрхэлсэн дэд захирал Д.Гантуулыг 2022 оны 05 дугаар сарын 17-ний өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлснөөр 64.0 сая төгрөгийн цалинтай холбоотой зардал, албан тушаалын автомашины 2.6 сая төгрөгийн шатахууны зардал, нийт 66.6 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т “Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно”, 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчиж 1,800.0 мянган төгрөг олгосонд төлбөрийн акт тогтоосон.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 21 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад алдаа, зөрчил илрээгүй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Дээрх хуулиас гадна ТБОНӨХБАҮХА тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад алдаа зөрчил илрээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус компанийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 139,578.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 13,067.7 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 11,768.2 мянган төгрөгийн албан шаардлага, 114,742.7 мянган төгрөгийн худалдан авах ажиллагаа, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэй холбоотой 2 зөвлөмжийн биелэлтийг шалгахад хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	13,067.7	3	13,067.7	100.0
Албан шаардлага	1	11,768.2	1	11,768.2	100.0
Зөвлөмж	2	114,742.7	2	114,742.7	100.0
Нийт дүн	6	139,578.6	6	139,578.6	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 55,572.7 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 1,800.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 45,052.7 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 8,720.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд хууль тогтоомжид заагаагүй шагналын дагалдах мөнгөн шагнал 300.0 мянган төгрөг олгосон тул буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоосныг аудитын явцад барагдуулсан.

2. Өмнөговь аймагт албан томилолтоор ажилласан албан хаагчид 1,500.0 мянган төгрөгийн албан томилолтын зардлыг давхардуулан олгосон зөрчил нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9.3-д заасантай нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

1. Тайлант оны 22,338.4 мянган төгрөгийн худалдан авалтын цахим төлбөрийн баримтыг харилцагч байгууллагуудаас гаргуулан аваагүй, 2,159.0 мянган төгрөгийн хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар ажил гүйлгээг бүртгэсэн зөрчил илэрсэн. Энэ нь аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7 дахь хэсэг, 20.1.4 дэх заалт, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “*Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар*”-ын 6.5-д заасантай тус тус нийцэхгүй байна.

2. Тайлант оны ТУЗ-аас баталсан бизнес төлөвлөгөөнөөс дотоод албан томилолт, хангамжийн материал, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зардлыг тус тус хэтрүүлэн зарцуулсан. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 203 дугаар тогтоолын 1.3 дахь хэсэгт заасантай тус тус нийцэхгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн 495 нэр төрлийн хөрөнгийг ашиглалтын байдлаас шалтгаалан актлах эсвэл дахин үнэлгээ хийх саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалт, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7.1 дэх хэсэгт заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн одоо ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгийг дахин үнэлэх, ашиглалтын шаардлага хангахгүй болсон хөрөнгийг акталж устгах саналыг ТӨБЗГ, холбогдох байгууллагад хүргүүлэх, цаашид дээрх алдааг давтан гаргахгүй байх.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд “Бид бүтээнэ” ХХК-тай байгуулсан ХХА-56/2022 тоот “Худалдах, худалдан авах гэрээ”-ний дагуу бэлтгэн нийлүүлсэн 20 нэр төрлийн 8,720.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшлыг үндсэн хөрөнгөд бүртгээгүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалт, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуй нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-тай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Компанийн хөрөнгөөр бэлтгэсэн 20 нэр төрлийн 8,720.0 мянган төгрөгийн өртөгтэй тавилгыг үндсэн хөрөнгийг 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд бүртгэж, цаашид дээрх алдааг давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 09 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 3101

Дархан сум

А0970290/ДАА-2023/15/НА-СТА-ТӨА

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Дарханы дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

ТУЗ-ийн баталсан тайлант оны бизнес төлөвлөгөөнөөс дотоод албан томилолтын зардал, хангамжийн материалын зардал, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зардлыг 20,555.3 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана”, 15.2.3-т “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх”, Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.8-д “Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна”, Эрчим хүчний сайд болон Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс баталсан компанийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөтэй тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл, зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 11 дүгээр сарын 30-ны дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг “Дарханы дулааны сүлжээ” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Д.Батжаргал, Ерөнхий нягтлан бодогч, санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга С.Лхагважаргал нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

Ц.МӨНХБАЯР

С.БАТЦЭЦЭГ

О.МЯГМАРСҮРЭН



003040097



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 57/02

Дархан сум

А09770290/ДАА-2023/15/НА-ОА-ТӨА

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Дархан дулааны сүлжээ" ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөговь аймагт албан томилолтоор ажилласан албан хаагчид 1,500,000.00 төгрөгийн албан томилолтын зардлыг давхардуулан олгосон нь холбогдох байгууллагаас ирүүлсэн нотлох баримтаар нотлогдож байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т "Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8-т "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Хууль, журам зөрчиж олгосон 1,500,000.00 (нэг сая таван зуун мянган) төгрөгийг Ерөнхий нягтлан бодогч, санхүү бүртгэлийн хэлтсийн дарга С.Лхагважаргалаар төлүүлж, Төрийн сан дахь Да.Хүү, торгуулийн орлогын 100190000988 тоот дансанд төвлөрүүлэх,

2. Актын биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 30-ны дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг "Дархан дулааны сүлжээ" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Д.Батжаргал, Ерөнхий нягтлан бодогч, санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга С.Лхагважаргал нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

С.БАТЦЭЦЭГ

О.МЯГМАРСҮРЭН

009050146



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 32/02

Дархан сум

А097890/ДАА-2023/15/НА-СТА-ТӨА

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Дарханы дулааны сүлжээ" ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд худалдан авалтын 22,338.4 мянган төгрөгийн цахим төлбөрийн баримтыг харилцагч байгууллагуудаас гаргуулан аваагүй, 2,159.0 мянган төгрөгийн хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар ажил гүйлгээ бүртгэсэн байна.

Энэ нь Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4-т "доор дурдсан бараа, ажил, үйлчилгээний зардал Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5-д "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл, зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Анхан шатны баримт бүрдэл хангаагүй ажил гүйлгээ гаргасан зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 11 дүгээр сарын 30-ны дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг "Дарханы дулааны сүлжээ" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Д.Батжаргал, ерөнхий нягтлан бодогч, Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга С.Лхагважаргал нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

С.БАТЦЭЦЭГ

О.МЯГМАРСҮРЭН

009049100